



## ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2015 оны 12 дугаар сарын 23-ны өдөр

Монголбанк нь 2016 онд Улаанбаатар хот болон орон нутгийн хэмжээнд иргэд, аж ахуйн нэгжүүдээс түүвэр судалгаа авах дараах 3 ажлуудыг хийж гүйцэтгэх судалгааны байгууллагыг сонгон шалгаруулна.

### АЖИЛ 1: “Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа”

Судалгааны хамрах хүрээ	Судалгааны объект	Түүврийн хэмжээ	Давтамж	Судалгааг гүйцэтгэх хугацаа	Гүйцэтгэх ажил
Улаанбаатар хот /9 дүүрэг/	Иргэд	1000	Улиралд 1 удаа буюу жилд 4 удаа	2016 оны I, II, III, IV улиралд	Түүвэр судалгаа авах, санал асуулгыг тусгай програмд шивж оруулах, өгөгдөл бэлтгэх
Улаанбаатар хот /9 дүүрэг/	Аж ахуйн нэгж	400	Жилд 3 удаа	2016 оны I, II улирал IV улиралд	Түүвэр судалгаа авах, санал асуулгыг тусгай програмд шивж оруулах, өгөгдөл бэлтгэх

### АЖИЛ 2: “Бизнесийн түүвэр судалгаа”

Судалгааны хамрах хүрээ	Судалгааны объект	Түүврийн хэмжээ	Давтамж	Судалгааг гүйцэтгэх хугацаа	Гүйцэтгэх ажил
Улаанбаатар хот /9 дүүрэг/ болон Төв аймаг	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид	1100	Жилд 1 удаа	2016 оны II улиралд	Түүвэр судалгаа авах, санал асуулгыг тусгай програмд шивж оруулах, өгөгдөл бэлтгэх
Орон нутаг /20 аймаг/	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид	1000	Жилд 1 удаа	2016 оны II улиралд	Монголбанкны орон нутаг дахь салбаруудын авсан санал асуулгыг тусгай програмд шивж оруулах, өгөгдөл бэлтгэх

**АЖИЛ 3: “Эдийн засгийн түүвэр судалгаа”**

Судалгааны хамрах хүрээ	Судалгааны объект	Түүврийн хэмжээ	Давтамж	Судалгааг гүйцэтгэх хугацаа	Гүйцэтгэх ажил
Улаанбаатар хот /9 дүүрэг/ болон Төв аймаг	Иргэд	1100	Жилд 1 удаа	2016 оны III, IV улиралд	Түүвэр судалгаа авах, санал асуулгыг тусгай програмд шивж оруулах, өгөгдөл бэлтгэх
Орон нутаг /20 аймаг/	Иргэд	2000	Жилд 1 удаа	2016 оны III, IV улиралд	Монголбанкны орон нутаг дахь салбаруудын авсан санал асуулгыг тусгай програмд шивж оруулах, өгөгдөл бэлтгэх

**Бүрдүүлэх материал:**

1. Компаний туршлага, ашиглаж буй програм хангамж болон боловсон хүчний ур чадварын талаарх товч танилцуулга /2 нүүрээс хэтрэхгүй/
2. Нотариатаар баталгаажуулсан аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /1 хувь/
3. Түүвэр судалгаа явуулах үнийн санал /судалгааны ажил тус бүр дээр/

Түүвэр судалгааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг **(976) 11-323990, (976) 11-322104** утаснаас лавлана уу.

Үнийн санал болон бусад материалыг доорх хаягаар 2016 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 16<sup>00</sup> – цагаас өмнө ирүүлнэ үү.

**Бага тойруу 3, 15160, Улаанбаатар, Монголбанкны “А” байр,  
Мөнгөний бодлого, судалгааны газар, Судалгааны хэлтэс  
МОНГОЛБАНК**